

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсгийн "төвд" гэсний дараа "болон анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэгч тусгай эмнэлэгт" гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"29.2.Төрийн өмчийн эрүүл мэндийн болон бусад салбарын байгууллагад 25 ба түүнээс дээш жил, өрх, сум, тосгон, анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэгч тусгай эмнэлэгт 10 ба түүнээс дээш жил ажилласан эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн бусад ажилтанд тэтгэвэрт гарахад нь нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг үндсэн цалингийн дунджаас нь тооцож олгох бөгөөд нэг удаагийн тэтгэмж тооцох цалингийн дундаж хэмжээ, тэтгэмж олгох шалгуур нөхцөлийг Төрийн албаны тухай хуульд заасан заасан журмыг баримтлан тогтооно."

**3 дугаар зүйл.** Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.8 дахь хэсгийн "салбарт" гэснийг "салбар, анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэгч тусгай эмнэлэгт" гэж өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг 2018 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ